

Хувийн эрх зүй дэх хууль тайлбарлах онцлог

Features of Legal Interpretation in Private Law

Түмэнжаргалын Мэндсайхан

Хууль зүйн ухааны доктор (PhD.).

*Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор*

*Улаанбаатар хот, Монгол Улс
mendsaikhan@num.edu.mn*



[Товч утга]

Хууль тайлбарлах нь хуулийг танин мэдэх арга, тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэх үндэслэл байхын зэрэгцээ хууль зүйн техникийн нэгэн чухал бүрдэл хэсэг мөн. Хэдийгээр хууль, хуулийн баримт бичиг өвөрмөц онцлогтой боловч бусад салбарын “тайлбарлах” нийтлэг арга, ерөнхий онолыг хууль зүйн салбарт ч ашиглах нь зохистой.

Хуулийн уг сурвалж, үзэл баримтлал, зорилго, чиг үүрэгт ач холбогдол өгөх үү, эсхүл хууль тогтоогчийн хүсэл зориг, эх бичвэрийн үг үсэг, шууд агуулгыг баримтлах уу, эсхүл цаг үеийн нөхцөл байдал, нийгмийн уур амьсгал, шинэ эрэлт хэрэгцээ, хүлээлтийг харгалзах уу, эсхүл уламжлал, ёс заншил, тогтвортой байдал, хатуу дэг журмыг чухалчлах уу гэдгээс тайлбар хийгч этгээдийн хандлага, тайлбарын үр дүн ихээхэн хамаарна. Хууль тайлбарлах субьектив ба объектив хандлага бий. Нийтийн ба хувийн эрх зүйн хууль тайлбарлах хандлага, арга багагүй ялгаатай. Хувийн эрх зүйд системийн болон учир шалтгааны аргыг ашиглан хууль тайлбарлах нь илүү түгээмэл ба объектив хандлагыг илүүтэй үзнэ.

Монгол Улсад хууль хэрэглэх, тайлбарлах арга ажиллагааг төлөвшүүлж, хууль хэрэгжүүлэгчийн дур зорго, шүүгчийн үзэмжийг зохих түвшинд хязгаарлах, хуулийн нэгдмэл практик бий болгох асуудал тулгамдсан хэвээр байна. Тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэх зорилгоор хуулийн хэм хэмжээг тайлбарлах ойлголт, арга ажиллагаа, хандлага болон хувийн эрх зүй дэх хууль тайлбарлах онцлог, манай улсын өнөөгийн практикийг энэхүү өгүүлэлд хөндөж бичлээ.

[Түлхүүр үг]

Иргэний хууль, Хууль хэрэглэх, Хууль тайлбарлах, Хуулийн албан ёсны тайлбар, Хууль зүйн техник, Субьектив хандлага, Объектив хандлага, Хэл зүйн арга, Түүхчилсэн арга, Системийн арга, Учир шалтгааны арга, Өрсөлдөгч хэм хэмжээ, Салаа утга, Эрх зүйн хийдэл.

I. Оршил

“Хууль тайлбарлах” ойлголт. Аливаа баримт бичиг, тэмдэг тэмдэглэгээний бодит утга, агуулгыг олж тогтоох, юмны утга агуулга, учир шалтгааныг дэлгэрүүлэн хэлж, таниулж өгөх үйлдлийг “тайлбарлах” гэдэг ерөнхий нэр томъёогоор илэрхийлдэг¹. Харин хууль зүйн ихэнх толь, сурах бичигт хуулийн тайлбарыг “хуулийн зүйл, заалт буюу эрх зүйн хэм хэмжээний бодит, жинхэнэ утга агуулгын тодруулга, тайлал” хэмээн тодорхойлсон байдаг².

Колумбийн их сургуулийн профессор Грийнэволт хүний амьдралын олон талт үйл ажиллагаанд холбогдох тайлбарын хэлбэр дүрс, арга хоорондоо харилцан уялдаа холбоотойг нотлох оролдлогыг өөрийн “Legal Interpretation” бүтээлдээ хийсэн байдаг³. Хүний мэдэрхүйн эрхтэн, далд ухамсраар хүлээн авч буй бүхий л мэдээлэл (шашны сургаал, утга зохиол, уран зураг, урлагийн бүтээл, хууль, гэрээ, албан бичиг, захидал, сүлд, билэг тэмдэг г.м.)-ийн утга агуулгыг тогтоож ойлгоход уг мэдээллийн зохиогч ба хүлээн авагчийн бодол санаа, хүсэл зориг, хувийн байдал, хандлага хэрхэн нөлөөлөх, цаг хугацааны хүчин зүйл, мэдээлэл агуулсан эх сурвалжийн хэлбэр, арга техник үүнд ямар ач холбогдолтой байх вэ зэрэг асуултын хүрээнд “тайлбарлах”, “тайлбар хийх” үйл ажиллагаа голлон явагдахаар байна. Хуулийн тайлбар нь бусад салбараас тусгаарлагдсан арал биш бөгөөд ийнхүү тайлбар хийхдээ хэл зүйн философ, үг зүйн тайлбар, шашины тайлбар, хөгжим, тайз дэлгэцийн бүтээл гүйцэтгэгчдийн тайлбар болон тайлбарын ерөнхий онолын олон арга, хэлбэрийг ашиглах ёстой гэсэн профессор Грийнэволтийн саналыг үгүйсгэх аргагүй юм. “Тайлбарлах гэдэг бол ямар нэгэн зүйлийг тухайлбал, мэдэгдэл, дохио зангаа, бичвэр эсвэл яруу найраг, уран зургийг ч юм уу ямар нэгэн тодорхой бөгөөд өвөрмөц арга замаар ойлгож танин мэдэх оролдлого, ... яг байгаа байдлаар нь бодитоор маш нямбай харуулахыг зорих, ...

¹ Монсудар хэвлэлийн газар, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, *Монгол хэлний хураангуй тайлбар толь бичиг* (Анхны хэвлэл), (Улаанбаатар: Монсудар, 2009), 608 дахь тал.

² *Black's Law Dictionary* 825 (7th ed. 1999): interpretation/тайлбар/ – ямар нэгэн хууль, хууль зүйн баримт бичгийн агуулга, утгыг тодорхойлох үйл ажиллагаа. Должингийн Баярсайхан, Эрх зүйн онол (3 дахь хэвлэл), (Улаанбаатар: Эжитмо, 2010, 201 дэх тал: эрх зүйг тайлбарлах гэдэг нь эрх зүйн хэм хэмжээний утга агуулга, хэллэг, нэр томъёо, заалт, зарчмыг тодруулан тогтоох, ... эрх зүйг ойлгох, танин мэдэх үйл явц, Чойжилын Нямсүрэн, Эрх зүй, төрийн ерөнхий онолын зарим асуудал, (Улаанбаатар: 1995), 62 дахь тал: эрх зүйн хэм хэмжээний утга санаа, агуулгыг тодруулах, нээн харуулах үйл ажиллагаа гэж тус тус тодорхойлсон байна.

³ Kent Greenawalt, *Legal Interpretation: Perspectives from other Disciplines and Private Texts*, (Oxford university press, 2010), 3.

зохиогчийн бүтээлд тайлбарлагчийн үнэт зүйлсийг тулгах бус, харин зохиогчдынх нь жинхэнэ бодит, түүхэн сэдэл санаархлыг гаргаж ирнэ гэсэн үг юм” хэмээн профессор Дворкин мөн нэгэн адил үзжээ⁴.

Хууль бол хууль тогтоогчийн хүсэл зоргийг илэрхийлсэн эх сурвалж юм. Бичмэл хууль ямар нэгэн хэлээр, тухайн хэлний дүрмийн хүрээнд үг, өгүүлбэрээр хэлбэржсэн байна. Хэдийгээр хууль тогтоогч хуулийн эх бичвэр, хэл найруулгыг батлан тогтоож байгаа боловч уг эх бичвэр бусад этгээдэд яаж ойлгогдох уу, тодорхой хэрэг тохиолдолд хэрхэн хэрэглэгдэх үү гэдэг олон хүчин зүйлээс шалтгаална. Аман болон бичмэл хууль, хуулийн эх сурвалжийн агуулга, утгыг тодруулан ойлгох эсхүл ойлгомжтой байлгах, эрх зүйг хөгжүүлэх зорилгоор хуульчид хуулийн тайлбар хийх, хуулийн нэр томьёоны тодорхойлолт ашиглах зэрэг олон арга хэрэгслийг хууль хэрэглэж хэрэг маргаан шийдвэрлэх болсон үеэс ашиглаж байв⁵. Эртний Грекийн сэтгэгч Цицероны “шүүгч бол ярьдаг хууль, харин хууль дуугүй шүүгч” хэмээх үгэнд⁶ шүүгч хуулийг тайлбарлагч, маргааны талуудад хуулийг ойлгуулагч, хуулийн агуулгыг ярьж хэлж өгөх хүн гэсэн санаа бий. Хуулийн хэм хэмжээ, нэр томьёо, үг хэллэгийн агуулга эргэлзээтэй, ойлгомжгүй, олон утгатай бөгөөд тодорхой хэрэг маргаан шийдвэрлэх зорилгоор хэрэглэхэд бэрхшээлтэй үед хууль тайлбарлах асуудал хөндөгдөнө. Хуулийн тайлбар нь тухайн кэйсийн шийдлийг олоход хийгдэх ёстой олон зүйлсийн зөвхөн нэг үе шат гэж профессор Моригова үзсэн байна⁷. Үнэхээр тодорхой хэрэг, үйл баримтад холбогдуулан хуулийг тайлбарлахгүйгээр тухайн хэргийг шийдвэрлэх боломжгүй тохиолдол олон байдаг. Нийгмийн харилцаа өргөжиж олон талтай болох, шинэ технологи, соёл нэвтрэх, зарим бүлгийн онцгой эрх, ашиг сонирхол хүлээн зөвшөөрөгдөх зэрэг урьдчилан төсөөлөөгүй нөхцөл байдлын улмаас хууль тайлбарлах илүү чөлөөт орон зай үүснэ.

Хуульд хандах эхний алхам танин мэдэхүйн аргад түшиглэнэ. Хууль гэж юу вэ, ямар төрөл, хэлбэртэй байна, уг гарвал, зорилго, мөн чанар нь юунд оршиж байна, ямар тохиолдолд хэн уг хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх боломжтой эсхүл үүрэгтэй зэргийг тогтоох шаардлага тулгарна. Хуульч, шүүгчийн ажиллагаа бол эрх зүйн

⁴ Роналд Дворкин, *Хуулийн эзэнт гүрэн* (Орч. Я.Очирсүх), ХЗҮХ-ийн хэвлэх үйлдвэр, 2015, 56-57 дахь тал.

⁵ Хутыз М.Х. Римское частное право: Курс лекций. – М.: Былина, 1994. – 20 с: Эртний Ромд нэр хүнд бүхий хуульчдад шүүх заавал дагаж мөрдөх албан ёсны тайлбарг дүйцэхүйц хариулт бичиг (jus respondendi) өгөх эрхийг олгож байжээ.

⁶ Cicero: de Legibus III, (2)

⁷ Моригова Яасутомо, “Хуулийг тайлбарлан хэрэглэх ажиллагаанд тогтвортой байдал ба шударга ёс зэрэгцэн орших нь”, *Шүүх эрх мэдэл сэтгүүл*, (3), 2015, 9 дэх тал.

танин мэдэхүй бөгөөд тодорхой хэрэг явдлын хувьд үйлчилж буй бүхий л хууль тогтоомжийг судлан тогтоох, тайлбарлаж хэрэглэх чиг үүрэгтэй холбоотой болохыг Австри, АНУ-ын хуульч, философич Ханс Кельзен өөрийн зохиолд дурдсан байдаг⁸. Түүний үзсэнээр хууль хэрэглэх явдал нь оюун ухааны бодож сэтгэх, зөв үндэслэл гаргах (reasoning) чадварыг шаардана.

Ромын эзэнт гүрний үеэс эрх зүйн хийсвэр хэм хэмжээг урьдчилан тогтоож ашиглах явдал нилээд өндөр хэмжээнд хөгжсөн юм⁹. Юстины төрөлжүүлэн эмхтгэсэн хуулийг иш үндэс болгож 13 дугаар зуунаас эхлэн Европын улсуудад ийм нийтлэг хийсвэр хэм хэмжээ агуулсан бичмэл хуулийн эх сурвалжийг нэвтрүүлснээр орчин үеийн хуулийн тогтолцоо бүрдэж эхэлжээ. Харин Английн хаан, түүний шүүх заншлын хуулийн жишиг дээр үндэслэн нийтийн хуулийг хөгжүүлсэн нь Английн төрийн өөрийнх нь хүлээн зөвшөөрөгдөх үндэс болжээ. Өнөөгийн өндөрлөгөөс харвал, нийтлэг эрх зүйн болон иргэнлэг эрх зүйн тогтолцоо бүхий аль ч улс оронд хийсвэр нийтлэг хэм хэмжээ агуулсан хууль тогтоох хүрээ улам өргөжиж ирсэн ба мэргэшсэн хуульч, шүүгчийн дэмжлэггүйгээр хуулийг тайлбарлан ойлгож хэрэглэхэд бэрхшээлтэй болжээ. Сүүлийн үед зарим улсад нүсэр түвэгтэй хуулиас татгалзах, норматив зохицуулалтыг багасгах арга хэмжээ авах сөрөг эрмэлзэл бий болжээ.

Өмнө дурдсанчлан хуулийг хэлбэржүүлэн нэгдмэл тогтолцоонд оруулах, түүнийг ойлгож хэрэглэх нь зоосны хоёр тал мэт нягт холбоотой юм. Аль аль нь хууль зүйн техникт суурилсан байх ёстой. Гэхдээ урт хугацаанд хууль тогтоогч, хууль хэрэглэгчийн хууль зүйн техник болон түүнийг хэрэглэх мэдлэг, ойлголт, хандлагад завсар зай гарах, зөрүү үүсэх явдал байж болно. Ихэнх улсад хууль боловсруулан батлах, уг хуулийг зөв ойлгож хэрэглэхэд ашигладаг тодорхой дүрмүүд бий. Эдгээр дүрмийг хуулиар эсхүл захиргааны хэм хэмжээгээр эсхүл мэргэжлийн хүрээнд тогтсон заншил, уламжлалаар тогтоодог. Монгол Улсын хувьд ийм хууль зүйн техникийн зарим хэсгийг Хууль, Улсын их хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль, Хууль зүйн яамны журмаар тогтоож байв. Хууль тогтоомжийн тухай хууль 2015 оны 5 дугаар сарын 29-ны өдөр батлагдаж, 2016 оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.

Дүгнэж хэлбэл, эрх зүйн хэм хэмжээг нэг мөр зөв ойлгож хуулийг хэрэгжүүлэх, хэрэглэх үйл ажиллагаанд дөхөм болох үүднээс мэргэшсэн хуульч, шүүгч хуулийг тайлбарлана. Хууль тайлбарлах

⁸ Ханс Кельзен, *Хэм хэмжээний тухай ерөнхий онол*, (Орч. М.Хатанбаатар), Мэргэн Их Монгол, 2013, 230-231 дэх тал.

⁹ Хутыз М.Х. Римское частное право: Курс лекций. – М.: Былина, 1994. – 6-7 с.

нь хуулийг танин мэдэх арга, тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэх үндэслэл байхын зэрэгцээ хууль зүйн техникийн нэгэн чухал бүрдэл хэсэг болно. Бусад салбарын “тайлбарлах” нийтлэг арга, ерөнхий онолыг хууль зүйн салбарт ч ашиглах нь зохистой.

II. Хууль тайлбарлах хандлага

Тайлбарлах нь олон талт нарийн мэргэжлийн үйл ажиллагаа учраас тайлбарлах олон хандлага байх боломжтой. Цагийн үеийн байдал, улс төр, нийгмийн хүчин зүйл ч үүнд нөлөө үзүүлнэ. Хууль тайлбарлах хандлага, чиг баримжааг тодорхойлоход тайлбарлан хэрэглэх хэм хэмжээний улс төрийн бодлого, идеаль, нийгмийн зөвшилцлийн цэгийг олж тогтоох явдал мөн чухал ач холбогдолтой¹⁰. Аль өнцгөөс харах, юунд тулгуурлах, юуг чухалчлахаас хамаарч хандлага тодорхойлогдоно.

Хууль тогтоогчийн хүсэл зоригийг голлон судлах уу эсхүл хууль хэрэглэгчийн бие даасан байр суурьнаас асуултыг тавих уу эсхүл жирийн иргэдийн нүдээр харах уу гэдгээс шалтгаалан хууль тайлбарлах хандлага өөр өөр болно. Профессор Грийнэволт зохиогч (яригч), хүлээн авагч (уншигч, сонсогч) ба дамжуулагдаж буй мэдээлэл (эх бичвэр, үг яриа) гэсэн гурван бие даасан хүчин зүйлийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг ялгамжтай тодорхойлсны үндсэн дээр хуулийн эх бичвэрийг тайлбарлахад харгалзах долоон шалгуурыг санал болгожээ¹¹. Түүнчлэн зөвхөн эх бичвэрийг төдийгүй түүхэн нөхцөл байдал, хөгжил болон хэрэг маргаан шийдвэрлэж байсан практик үйл ажиллагааг хууль тайлбарлахад харгалзан үзэх шаардлагатайг тэрээр тэмдэглэсэн байна.

Хууль тогтоогчийн хүсэл зоригт анхаарвал субъектив, харин хуулийн эх бичвэрийн агуулгад нийгмийн хөгжил, эрх зүйн харилцааны өөрчлөлт, тухайн цаг хугацааны бодит нөхцөл байдалд нийцүүлэн ердийн ухаалаг хүний байр сууриас уян хатан хандахыг объектив хандлага гэж үздэг¹².

Хууль тайлбарлах хандлага нь хууль, түүний уг сурвалжийг хэрхэн танин мэдэж ойлгохоос ихээхэн хамаарна. Хууль гэдэг бол нийгмийг барьж багладаг шударга ёсны тухай хийсвэр дүрэм, журмуудын цогц гэсэн тодорхойлолтыг Фрэнсис Фукуяма “Улс

¹⁰ Нанзаддоржийн Лүндэндорж, “Хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүй” Шүүх эрх мэдэл, (1), 2015, 9-11 дэх тал.

¹¹ Kent Greenawalt, Legal Interpretation: Perspectives from other Disciplines and Private Texts, (Oxford university press, 2010), 5-11.

¹² Харьцуулан үзэх: Reinhold Zippelius, Juristische Methodenlehre, 10., neu bearb. Aufl., München, Deutschland, 2006, S. 21-23, Нанзаддоржийн Лүндэндорж, “Хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүй” Шүүх эрх мэдэл, (1), 2015, 11-12 дахь тал.

төрийн тогтолцооны сурвалж” номдоо ашиглажээ¹³. “Нийгмийн дэг журам бол дээрээс-доошоо тулгасан төвлөрсөн төлөвлөгөө биш, харин хууль журмыг туршиж байгаа олон зуун мянган хувь хүмүүсийн өөр хоорондын харилцаа юм. Нийт хүн амын хүсэл зоригийг тусгасан, одоогийн төрийн хүсэл зоригоос илүү өндөр дээд, түүний хууль тогтоомжийн агуулгыг хязгаарлаж чадах, урьд өмнөөс оршсоор байсан тийм хууль байсан” гэж либертар үзлийн эцэг Хаек өөрийн алдартай “Эрх зүй, хууль тогтоомж ба эрх чөлөө” зохиолдоо дурдсан байна¹⁴. Энэ нь эрт цагийн заншил, шашны номлол, сургаал, маргаан зөрчил шийдвэрлэж байсан шүүхийн шийдвэрийн жишиг, жам ёсны эрхийн хүлээн зөвшөөрөлт зэрэг хэлбэрээр дамжин улс орнуудын эрх зүйн тогтолцоо бүрэлдэж ирсэн ба хэн нэгэн хууль тогтоогчийн оюун санааны бүтээл биш гэдэг санааг илтгэж байна.

Орчин үед ихэнх улс төрийн эрх мэдэлтнүүд хууль тогтоох чадвартай боловч өмнө оршиж байгаа хууль, нийтлэг хүлээн зөвшөөрсөн үзэл санаанд нийцүүлэн шинэ хууль тогтоох ёстой болохоос ямар ч хамаагүй хуулийг дур зоргоор гаргах боломжгүй юм. Ийнхүү “байгаль нийгмийн хууль, зүй тогтол, хүний үндсэн эрх, эрх зүйн нийтлэг зарчмууд, зүй ёс, эрх зүйн үнэт зүйл зэргийг хуулийн аливаа хэм хэмжээний агуулгын стандарт, үндэслэгээ болгодог” хууль дээдлэх ёс (Rule of Law)-ны онол өргөн тархаж, түгээмэл практик болж байна¹⁵. Мэдээж тухайн улс орны улс төрийн дэглэмээс хамаарч эрх мэдэлтний хууль дүрэм тогтоох хэмжээ хязгаар хэмжигдэх боловч уламжлал, заншил, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс суртахууны хэм хэмжээг дагаж мөрдөх нийтлэг жишиг хүний аль ч нийгэмд түгээмэл байсаар ирсэн билээ. Энэ өнцгөөр харвал хууль тогтоогчийн хүсэл зоригоос илүүтэй ард түмний хүсэл зориг, нийгмийн зөвшилцөл, байгалийн хуульд үндэслэсэн нийгмийн амьдралын түгээмэл учир шалтгаан, үзэгдлийг харгалзан үзэхээс өөр аргагүй болно.

Эрх зүй нь хүмүүс хоорондын харилцааг зохицуулж, эд баялаг, үүрэг хариуцлагыг зөв оновчтой хуваарилах, эсрэг тэсрэг ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх, гэмт үйлдлийг шийтгэх, товчдоо нийгэмд үүсэж буй эрх зүйн асуудлыг зөв шударга шийдвэрлэх, нийгэмд зөвшилцөл, энх амгалан, эвлэрэл зохицол, дэг журам бий болгох арга хэрэгсэл юм. Шударга ёсны асуултад хариулж шийдвэрлэх нь эрх зүйн гол чиг үүрэг мөн. Шударга ёсыг тогтоохоос гадна эрх зүйн

¹³ Фрэнсис Фукуяама, *Улс төрийн тогтолцооны сурвалж*, (Орч. Э.Ариунсанаа), II боть.

¹⁴ Friedrich A. Hayek, *Law, Legislation and Liberty*, (University of Chicago press, 1976), 72-74.

¹⁵ Профессор Нанзаддоржийн Лүндэндорж Шүүх эрх мэдэл сэтгүүлийн 2015 оны 1 дэх дугаарын эрхлэгчийн зурваст “Rule of Law” буюу эрх зүйд захирагдах ёсны хоёр үндсэн утгыг тодорхойлж бичсэн байна.

тогтвортой, урьдчилан төсөөлөгдөх байдал, түүнчлэн ашиг сонирхлын ухаалаг зохистой тэнцвэртэй хамгаалалтыг хангах үүргийг эрх зүй гүйцэтгэх ёстой¹⁶. Эдгээр зорилго, чиг үүргийг хууль тайлбарлах үед заавал харгалзан үзэх чмтой боловч тэдгээр нь хоорондоо нарийн төвөгтэй харилцаанд байх бөгөөд бие биенээ нөхөх, зарим үед хоорондоо зөрчилдөх явдал гарна.

Жишээ нь: Үүрэн холбооны үйлчилгээ, хэрэглэж буй гар утасны тоног төхөөрөмжтэй холбоотой харилцааг эрх зүйгээр зохицуулах асуудал.

Техник технологийн шинэтгэлийн хурдцаас хамаарч эрх зүйн зохицуулалт хоцрогдох эсхүл тогтворгүй байх нөхцөл үүсэх ба энэ тохиолдолд хэрэглэгчийн эрх ашиг зөрчигдөнө. Нөгөө талаас үйлдвэрлэгч, хөрөнгө оруулагчдад эрсдэл үүсэх буюу эрх зүйн аюулгүй байдал хангагдахгүй болно. Анхаарал татсан нэг асуудал бол хэрэглэгчийн аюулгүй байдал, нууц хадгалалт юм. Үндэсний аюулгүй байдал ч энд хөндөгдөнө. Бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн учруулсан гэм хорын харилцаанд үйлдвэрлэгчийн хариуцлага болон гэрээний эрх чөлөө, хариуцлагаа хязгаарлах боломжийг хэрэглэгчийн эрх ашиг, үүрэг хариуцлагатай зохистой уялдуулах нь амар ажил биш. Энэ жишээнд хамаарах хууль тогтоомжийг хэрэглэх үед эрх зүйн зохицуулалтын үүрэг, зорилгыг харгалзах шаардлага зүй ёсоор үүснэ.

Эрх зүйн хэм хэмжээний нийтлэг шинж буюу бүх нийтэд зориулагдсан байдал нь эрх зүйн тогтвортой, аюулгүй байдлыг хангах бөгөөд тэгш бус, дур зоргоор хандах явдлаас урьдчилан сэргийлнэ. Ийм нийтлэг шинж нь тодорхой тохиолдол, хэрэг маргааны үед тухайн нөхцөл байдлын онцлогт тохирохгүй байх эрсдэлтэй ба шүүхээр хэрэг маргааныг шийдвэрлэх үед ч энэ сул тал давтагдах боломжтой. Иймд нийтлэг ба тусгай нөхцөл байдлын шударга ёсыг хангахын тулд хууль тайлбарлан хэрэглэх арга, шүүхийн шийдвэрийн үндэслэлд анхаарах шаардлага үүснэ.

Жишээ нь, шударга бус эзэмшигчийн хүлээх үүрэг, хариуцлага, эдлэх эрх, эдийн хариуцлага хүлээлгэх, хариуцлагаас чөлөөлөх, шударга бус эзэмшигчид хамааруулахгүй байх онцгой журам зэргийг нийтлэг байдлаар зохицуулсан хууль гаргаж болно. Харин бодит нөхцөл байдал, тухайн этгээдийн хувийн байдал, эзэмшилд байгаа эд зүйлийн онцлогоос хамаарч шударга ёсны үүднээс хуулийг ялгамжтайгаар тайлбарлан хэрэглэх орон зай байж болох уу.

Дүгнэж хэлэхэд, хуулийн уг сурвалж, үзэл баримтлал, зорилго,

¹⁶ Reinhold Zippelius, *Juristische Methodenlehre*, 10., neu bearb. Aufl., München, Deutschland, 2006, S. 8.

чиг үүрэгт ач холбогдол өгөх үү, эсхүл хууль тогтоогчийн хүсэл зориг, эх бичвэрийн үг үсэг, шууд агуулгыг баримтлах уу, эсхүл цаг үеийн нөхцөл байдал, нийгмийн уур амьсгал, шинэ эрэлт хэрэгцээ, хүлээлтийг харгалзах уу, эсхүл уламжлал, ёс заншил, тогтвортой байдал, хатуу дэг журмыг чухалчлах уу гэдгээс тайлбар хийгч этгээдийн хандлага, тайлбарын үр дүн ихээхэн хамаарна.

III. Хууль тайлбарлах арга

Хууль тайлбарлах үндсэн дөрвөн аргыг хууль зүйн болон шүүхийн практикт түгээмэл ашиглаж байна. Энэхүү аргын тухай германы онолч Фриедрих Карл фон Савини /1979-1861/ анх тодорхойлж бичсэн байдаг¹⁷. Үүнд:

- Хэл зүйн арга (Grammatical interpretation) нь хуулийн эх бичвэрийн үгийн агуулгыг чухалчлана.

- Түүхчилсэн арга (Historical interpretation) хууль тогтоох түүх, уламжлалыг ашиглах ба хууль тогтоогчийн хүсэл зориг, төсөөлж байсан зүйлийг олж тогтооход чиглэнэ.

- Системийн арга (Systematic interpretation) эрх зүйн болон хуулийн нэгдмэл тогтолцооны хүрээнд хуулийн зүйл заалтыг авч үзэн тайлбарлахыг эрмэлзэнэ.

- Учир шалтгааны арга (Teleological interpretation) нь хуулийн зорилго, хууль боловсруулсан үзэл баримтлалыг харгалзан үздэг.

Дээр дурдсан аль аргыг илүү чухалчлах вэ? гэдэг багагүй маргаантай. Германы зарим хуульчид хэл зүйн аргыг илүүд үзэх ба ингэхдээ ардчилсан арга журмаар батлагдаж хүлээн зөвшөөрөгдсөн учраас эх бичвэр, түүний үгийн агуулгыг давуу байдалтай баримтлах ёстой гэсэн санааг үндэслэл болгодог¹⁸. Орчин үеийн нийтлэг эрх зүйн тогтолцоо бүхий улсуудад ч шүүхээс хууль тогтоох буюу хуулийг өргөжүүлэн тайлбарлахыг зохимжгүй хэмээн үзэж байна. Ер нь хуулийг уянга хатан, мэдрэмжтэй тайлбарлах явдал эрсдэлтэй, буруугаар ашиглах үүд хаалгыг нээж өгөх аюул дагуулна. Хууль тогтоогчдын хүсэл зориг, хуулийн нэгдмэл тогтолцооны дотоод уялдаа холбоог үгүйсгэж харгалзан үзэхгүй байх нь яавч ухаалаг биш. Түүнчлэн хуулийн зорилго, баримтласан зарчимд нийцүүлэн тайлбарлах, хуулийн үр нөлөөг хязгаарлах эсхүл өргөжүүлэх боломжийг орхигдуулж болохгүй. Ялангуяа манай улсын хувьд онцгой анхаарах асуудал бол хууль тогтоогчид тухайн хуулийн бичвэрийн талаар өөр өөр ойлголт төсөөлөлтэй байсан буюу хууль тогтоогчийн нэг биш хэд хэдэн хүсэл зориг байх, хууль тогтоох

¹⁷ Savigny, System des heutigen Roemischen Rechts I, 1840, S. 213-214.

¹⁸ Zippelius R, Juristische Methodenlehre, 10. Aufl. 2006 S.48.

үйл ажиллагаанд алдаа зөрчил гарах, хууль тогтоомжийн нэгдмэл бодлого хэрэгжихгүй байх тохиолдолд сүүлийн хоёр аргыг ашиглах шаардлага зайлшгүй үүснэ.

Хамгийн чухал арга нь хэл зүйн арга юм. Хуульд юу бичсэн түүний ердийн, түгээмэл, орчин үеийн агуулгыг баримтлах ёстой. Хэрэв хэл зүйн хувьд ойлгомжтой, тодорхой байгаа бол хуулийг тайлбарлах шаардлагагүй. Гэвч ихэнх үг олон утгатай, толь бичгээс үзсэн ч ялгаагүй ийм л байдаг. Хууль зүйн үр дагавар бий болгохын тулд тухайн үг аль болох тодорхой нэг эсхүл хязгаарлагдмал тооны утгатай байх нь зохимжтой. Жирийн монгол хэлээр яригч, бичигч хүний үг яриа, албан бичигт тухайн үг, өгүүлбэр ямар утга агуулгатай орж, бусад этгээдэд яаж ойлгогдож байна вэ гэдгээр хуулийг нэгэн адил ойлгож болох уу гэдэг асуулттай. Ийм учраас хууль зүйн практик, хууль тогтоох үйл ажиллагаанд зарим дүрэм, арга ажиллагаа /техник/ ашиглахад хүргэдэг. Хууль зүйн арга ажиллагааны түгээмэл нэг арга бол тодорхой ухагдахуун, ойлголтыг тэмдэглэх зорилгоор нэр томъёо оноож ашиглах, уг нэр томъёоны агуулга, хамрах хүрээ, багтаамжийг тодорхойлох явдал юм. Зарим тохиолдолд хуульд тусгайлан “нэр томъёо”-ны тодорхойлолт оруулах эсхүл хуулийн хэм хэмжээнд уг нэр томъёог тодорхойлох аргыг ашиглаж байна. Үүнийг жишээгээр тодруулья:

Жишээ 1: “Төрлийн хүн”-ийг Гэр бүлийн тухай хуулийн нэр томъёоны хэсэгт “гэрлэгчийн эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охин, тэдгээрийн хүүхэд” гэж тодорхойлсон байна.

Жишээ 2: “Эзэмшил”-ийг хуулийн бие даасан хэм хэмжээгээр тодорхойлсон байна. Иргэний хуулийн 89.1-д “Хүсэл зоригийн дагуу эрх, эд юмсыг хууль ёсоор мэдэлдээ авах замаар эзэмшил үүснэ” гэж тодорхойлсон нь багагүй маргаан дагуулдаг. Бодит байдалд эд юмсыг мэдэлдээ байлгах үед эзэмшил үүсэх үзэл баримтлалыг хууль тогтоогчид баримталсан бөгөөд энэ маргааныг хэл зүйн тайлбараар шийдэх боломжгүй. Харин системийн тайлбараар шийдвэрлэх гарц бий.

Иргэний эрх зүйн салбарт хууль тайлбарлах системийн аргыг өргөн ашигладаг. Иргэний эрх зүйн хууль тогтоомжийн тогтолцоо, бүтэц, хэм хэмжээний бүтээц, нэр томъёо маш нарийн тодорхойлогдсон, нягт уялдаа холбоотой байдгаас ийм шаардлага зүй ёсоор тавигддаг.

Түүхчилсэн аргыг хэрэглэх үед хууль тогтоогчийн хүсэл зориг, тухайн үеийн нийгмийн нөхцөл шаардлага, улс төрийн идеаль зэргийг харгалзана. Манай улсын өнөөгийн нөхцөлд өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, уг төслийн үзэл баримтлал, танилцуулга, төсөл хэлэлцсэн УИХ-

ын нэгдсэн хуралдаан, байнгын хороодын хуралдааны тэмдэглэлийг судалж хууль тогтоогчийн хүсэл зоригийг тогтоож болно. Хууль мөрдөгдөөд жил хугацаа удах болох тусам хууль тогтоогчийн хүсэл зоригийг тогтоох ач холбогдол буурах боломжтой ба субъектив хандлага багасч, объектив хандлага давамгайлах болно.

Иргэний хууль тогтоомж нь талуудын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, зөрчигдсөн эрхийг сэргээн хамгаалах зэрэг зарчмыг баримтлан эдийн ба эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулах чиг үүрэг, зорилготой. Энэхүү чиг үүрэг, учир шалтгааныг үндэслэн тайлбар хийх ёстой. Монгол Улсын Иргэний хуулийн 4.2-д “Төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээ байхгүй бол тухайн харилцааг иргэний эрх зүйн агуулга, зарчим, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд нийцүүлэн зохицуулна” гэж заасан нь учир шалтгааны аргаар тайлбарлах ач холбогдлын чухлыг илтгэж байна. Хууль батлахад баримталсан үзэл баримтлал, онолын үндэслэлийг заавал харгалзан үзэж хууль тайлбарлана гэдэг бол харьцуулсан эрх зүйг сайн судалж, үндэсний эрх зүйн сонголт, онцлогоо зөв ойлгож тодорхойлохоос эхэлнэ.

Дүгнэхэд, хувийн эрх зүйд системийн болон учир шалтгааны аргыг ашиглан хууль тайлбарлах нь илүү түгээмэл юм. Нэр томъёоны тодорхойлолтыг хуульд өргөн ашиглаж байгаа нь хувийн эрх зүйн салбар эхлэн хөгжиж буй манай улсад шинэ ойлголт, ухагдахууныг нэг мөр ойлгож хэвшүүлэхэд чухал ач холбогдолтой.

IV. Нийтийн ба хувийн эрх зүй дэх хууль тайлбарлах ялгаатай байдал

Эрх зүйн зохицуулалтын хамрах хүрээ, эх сурвалж, арга ажиллагааны онцлог, ялгаа байдал нь нийтийн ба хувийн эрх зүйг зааглан ангилах шаардлагыг нөхцөлдүүлдэг¹⁹. Академич С.Нарангэрэл нарын тодорхойлолтоос үзэхэд эрх зүйн харилцааны агуулга, оролцогчийн эрх зүйн байдал нийтийн ба хувийн эрх зүйг зааглах гол шалгуур болжээ²⁰. Эрх тэгш, бие даасан чөлөөт байдлын зарчимд үндэслэн бодгаль этгээд, тэдгээрийн нэгдэл буюу хуулийн этгээд хооронд үүсэж буй хөрөнгийн болон амин хувийн харилцаа, ашиг сонирхлын зөрчлийг хувийн эрх зүй зохицуулна. Харин нийтийн сайн

¹⁹ Бяраагийн Чимид, *Үндсэн хуулийн үзэл баримтлал: нийтлэг асуудал*, Нэгдүгээр дэвтэр (Улаанбаатар: Хууль зүйн үндэсний төв, 2004), /Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд нийтийн ба тусгай(хувийн) эрх зүйн ойлголтыг нэвтрүүлэхийн учир/, 312-314 дэх тал.

²⁰ Содовсүрэнгийн Нарангэрэл, *Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо*, (Улаанбаатар: Адмон, 2001), 84-87 дахь тал.

сайхан, нийтлэг ашиг сонирхлыг хамгаалах, төрийн бүрэн эрх, зохион байгуулалт, засаглах үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон эрх зүйн хэм хэмжээний тогтолцоог нийтийн эрх зүйд хамааруулна.

Ромын хуульч Ульпиан тэртээ 3 дугаар зуунд нийтийн ба хувийн эрх зүй (jus publicum, jus privatum) гэсэн хоёр ойлголтыг зааглан “ромын улсын эрх үүрэгт хамаарах нь нийтийн, бие даасан этгээдэд хамаарах нь хувийн эрх зүй” гэж тодорхойлж байжээ²¹.

Нийтийн эрх зүйн харилцааны үндсэн оролцогч төр, төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хууль дээдлэх зарчмыг чанд сахих ёстой. Өөрөөр хэлбэл, хуулиар зөвшөөрсөн, тогтоосон хүрээнд албан тушаалтан эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Харин иргэний эрх зүйн харилцаанд хуулиар хориглосноос бусад тохиолдолд зөвшөөрсөн гэж ойлгодог. Энэхүү ялгаатай эрх зүйн байдал нь холбогдох хуулийг тайлбарлахад эрс ялгаатай хандлага, арга ажиллагаа шаардана. Нийтийн эрх зүйн албан тушаалтны эрх, үүргийн хувьд явцуу, хязгаарлагдмал, иргэний эрх зүйд өргөжүүлсэн, нээлттэй тайлбар хийх боломжтой.

Хувийн эрх зүйн харилцаанд оролцогчдын бие даасан байдал, гэрээний эрх чөлөөг илүүтэй хүндэтгэсэн диспозитив буюу зөвшилцөх шинжтэй зохицуулалтын аргыг өргөн хэрэглэдэг. Иймд иргэний эрх зүйн хуулиуд нь оролцогчдын үйлдэл/эс үйлдэхүй болон нөхцөл байдлыг тайлбарлах тухай олон зүйл заалтыг багтаахаас гадна оролцогчдын тохиролцоо, гэрээг тайлбарлах дүрмийг тогтоосон байдаг. Харин нийтийн эрх зүйд зохицуулалтын захирангуй аргыг түгээмэл хэрэглэж, оролцогчдын эрх, үүргийг тодорхой тогтоох зорилго тавьдаг учраас хуулийг тайлбарлах арга ч ялгамжтай болно.

Хувийн эрх зүйн салбарт хамаарах хуулийг аналогич буюу төсөөтэй байдлаар тайлбарлан хэрэглэх боломжтой. Харин нийтийн эрх зүйн хуулийг төсөөтэй хэрэглэж болохгүй. Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхийг хатуу хориглодог. Монгол Улсын Иргэний хуулийн 4 дүгээр зүйлд төсөөтэй хэрэглэх тусгай зохицуулалт байдаг.

Монгол Улс ром-германы эрх зүйн тогтолцоотой²², иргэний

²¹ Хутыз М.Х. Римское частное право: Курс лекций. – М.: Былина, 1994. – 5 с.

²² Бяраагийн Чимид, *Үндсэн хуулийн үзэл баримтлал: нийтлэг асуудал*, Нэгдүгээр дэвтэр (Улаанбаатар: Хууль зүйн үндэсний төв, 2004), /Зохистой тогтолцоог баримжаалах нь эрх зүйн шинэтгэлийг үр нөлөөтэй хийх үндэс болох нь/, 246-248 дахь тал: “... орчин үеийн Монголын эрх зүй ром-германыхтай илүү төрөлсөх талтай. ... Үндсэн хуулийнхаа үндэслэлийн хувьд ром-германы эрх зүйн бүлд хамаарна”, Ж.Амарсанаа, “Монгол Улсын эрх зүйн тогтолцоо ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил”, *“Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил” бага хурлын илтгэлийн эмхтгэл*, Улаанбаатар, 2004, 11 дэх тал. “... сүүлийн 80 орчим жилийн түүхэн туршлагаас үзвэл Монгол Улс яах аргагүй Ром-Германы буюу иргэний эрх зүйн тогтолцоотой улс юм” гэж тус тус

хуулийг шинэчлэн боловсруулж батлахад германы профессор, эрдэмтдийн оролцоо, зөвлөгөө чухал нөлөөтэй байсан²³, манай улсын Иргэний хуульд Германы иргэний кодекстой харьцуулахад бүтэц, системчлэлийн хувьд нийтлэг зүйл их байгаа²⁴ зэрэг учир шалтгааны улмаас иргэний эрх зүйн нэгдмэл байдал, харилцан уялдаа, бүхэллэг шинж ихээхэн ач холбогдолтой. Гэхдээ бизнесийн эрх зүйн зарим хууль /компанийн тухай хууль, үнэт цаасны зах зээлийн тухай хууль г.м./ англи-саксоны эрх зүйн бүлээс хуулбарлан авсан байдаг. Нийтлэг эрх зүйн хууль тогтоомжийг иргэнлэг эрх зүйнхтэй харьцуулбал одоохондоо тогтвортой, бүхэллэг нөхцлийг хараахан хангаагүй байна. Эдгээр нөхцөл байдал хууль тайлбарлахад нөлөөлөх нь дамжиггүй.

Товчхон дүгнэхэд, ихэнх улс орны иргэний хууль тогтоомж нь эртний ромын үеэс урт хугацаанд шинжлэх ухааны түвшинд хөгжиж, амьдралын сорилт шаардлагыг даван гарч ирсэн ба өргөн агуулга, нарийн бүтэц тогтолцоотой, төрөлжиж эмхтгэгдсэн, тогтсон үзэл баримтлал, зарчим, нэр томъёо, ухагдахуунтай буюу цэвэр мэргэшсэн хуульч эрдэмтэн судлаачдын бүтээл, профессор Дворкины тодорхойлсон “цуврал роман”²⁵ байдаг. Энд дурын хууль тогтоогчийн хүсэл зориг нэвтрэх зай завсар тун бага. Ийм учраас иргэний хууль тогтоомжийг тайлбарлахын тулд иргэний эрх зүйн харьцуулсан судлагаа хийх, үзэл баримтлал, онол сургаалаас суралцах, энэ талаарх гадаад, дотоодын судлаач, эрдэмтдийн ном зохиол, судлагааны бүтээлийг уншиж судлах зайлшгүй шаардлагатай.

V. Хувийн эрх зүйн хүрээнд хууль тайлбарлах онцлог шаардлага

Япон улсын Нагоягийн их сургуулийн профессор Моригова Яасутомо “хуулийг тайлбарласан аливаа тайлбар нь зорилтот объектыг таньж тогтоох, тухайн объектын агуулгыг тайлбарлах гэсэн хоёр элементийг заавал агуулсан байх ёстой” гэж үзсэн байна²⁶.

дүгнэсэн байна.

²³ Даваасүрэнгийн Наранчимэг, Дунхүүгийн Аюуш, “Монгол Улсын иргэний хууль тогтоомж ба эрх зүйн шинэтгэл”, *“Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил” бага хурлын илтгэлийн эмхтгэл*, Улаанбаатар, 2004, 126 дахь тал.

²⁴ Зохиогчийн бичсэн “Монгол Улсын Иргэний хуулийг ХБНГУ-ын Иргэний төрөлжсөн хуультай харьцуулан судлах нь” өгүүллийг *“Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил” бага хурлын илтгэлийн эмхтгэл*, Улаанбаатар, 2004, 133-137 дахь талаас үзэх.

²⁵ Роналд Дворкин, *Хуулийн эзэнт гүрэн* (Орч. Я.Очирсүх), ХЗҮХ-ийн хэвлэх үйлдвэр, 2015, 188-189 дахь тал.

²⁶ Моригива Яасутомо, “Хуулийг тайлбарлан хэрэглэх ажиллагаанд тогтвортой байдал ба шударга ёс зэрэгцэн орших нь”, *Шүүх эрх мэдэл сэтгүүл*, (3), 2015, 10 дахь тал.

Тэрээр тайлбарын объект нь талуудын маргаанаар тодорхойлогдсон зорилготой, шийдвэрлэх гэж буй тодорхой тохиолдол /кэйс/ байж болох ба мөн эрх зүйн хүчин чадлыг агуулж байдаг.

Хууль хэрэглэхийн тулд эхлээд тухайн холбогдох хэрэг маргааны үйл баримтыг тогтоож, хууль зүйн асуултыг тодорхойлно. Үүний дараа тухайн үйл баримтад хамаарал бүхий хуулийг олж тогтоох /зүйлчлэл хийх/, улмаар хуулийн үр дагаврыг тодорхойлох алхам хийнэ. Үүний тулд хуулийн тогтолцоо, хууль зүйн арга техникийг мэдэх ёстой. Хамаарал бүхий хуулийн хэм хэмжээг олж тогтоохын тулд хэм хэмжээний гипотезийн агуулгыг тодорхойлох ба өрсөлдөгч олон хэм хэмжээнээс зөв сонголт хийх ёстой. Харин хуулийн үр дагаврыг тогтоохын урьдач нөхцөл нь сонгосон хэм хэмжээний диспозици, санкци хэсгийн агуулгыг тодорхойлох явдал юм. Дүгнэж хэлбэл, хэм хэмжээний агуулгыг тодорхойлох ажиллагаа гипотез, диспозици, санкци гэх бүх хэсгийн хүрээнд хөндөгдөхөөр байна. Ийнхүү агуулгыг тогтоох үед ялангуяа хувийн эрх зүйн хууль тайлбарлах дараах дөрвөн онцлог шаардлага үүсэж болно:

1) Өрсөлдөгч хэм хэмжээ олон ба тэдгээрээс сонголт хийхэд бэрхшээлтэй байх.

Жишээ нь: Худалдагч тал гэрээг зөрчиж чанаргүй бараа нийлүүлсний улмаас худалдан авагчийн эд хөрөнгөд /чанаргүй барааг хэрэглэж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь гологдол болсон/ учирсан хохирлыг тодорхойлоход хуулийн аль зүйл заалтыг хэрэглэх буюу зүйлчлэл хэрхэн хийх асуулт тавигдсан гэж үзье. Энэ жишээнд Иргэний хуулийн 261.1 эсхүл 227.3, 254.1 дэх заалтын аль нэгийг сонгон хэрэглэх боломжтой.

2) Хуулийн тухайн хэм хэмжээний агуулга тодорхой бус, олон агуулга, салаа утгатай. Энэ үед агуулгыг тодруулах, үг өгүүлбэрийн утгыг тайлж гаргах.

Жишээ нь: Дээр дурдсан жишээнд “хохирол”-ийг хэрхэн ойлгож, тодорхойлох тухай асуултад шууд хариулах амаргүй. Энгийн үг ярианд “хохирол” ойлгомжтой мэт боловч хамрах хүрээ, төрөл, тооцох аргын хувьд маш өргөн агуулгатай, олон салаа утгатай байдаг. ИХ-ийн 227.3-д “... гарсан зардал, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтэл, ... зайлшгүй орох байсан орлогыг хохиролд” тооцсон нь хохирлын төрлийг задлан тодруулсан зохицуулалт байна. Гэхдээ зардал, алдагдал, орлого гэдэг ойлголтыг дахин тодруулах шаардлага хэвээр үлдэнэ. ИХ-ийн 261.1-д “... гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнөөс нөгөө талдаа учруулсан хохирлыг гэм хор арилгах нийтлэг журмыг баримтлан арилгах”, ИХ-ийн 229.1-д “гэм хорыг арилгахдаа эд хөрөнгөд учруулсан бодит хохирол болон олох ёстой байсан орлогыг нөхөн төлөх” тухай тус

тус заасан нь гэм хорыг хохиролтой холбож өгсөн зохицуулалт болжээ. ИХ-ийн 228.1-д “гэм хор арилгах үүрэг бүхий этгээд нөгөө талын зөрчигдсөн эрхийг гэм хор учруулахаас өмнөх байдалд сэргээх үүрэгтэй” гэсэн нь хэдий хохирлыг шууд тодорхойлоогүй боловч хохирлыг тогтоох хүрээ, хязгаар, зарчмыг тогтоосон байна.

3) Хуулийн хэм хэмжээнүүд хоорондоо зөрчилтэй, утга агуулгын хувьд алдаатай. Зөв зохистой хэм хэмжээг сонгож хэрэглэхийг шийдэх.

Жишээ нь: Дээр дурдсан жишээнд худалдан авагч ИХ-ийн 254.1-ийг үндэслэн гэрээг цуцлах тухай мэдэгдсэн гэж үзье. Ийм тохиолдолд хохирлоо хэрхэн тодорхойлж нэхэмжлэх эрхтэй байх вэ, “Цуцлах” гэсэн үг-ухагдахуун, түүний агуулга, үр дагаврыг хэрхэн ойлгох вэ гэдэг асуулт тавигдана. Уг нь энэ үг гэрээний эрх зүйд түгээмэл хэрэглэгддэг, агуулга нь тодорхой байдаг. Гэхдээ энэ ойлголт “татгалзах” гэдэг ойлголттой хэрхэн уялдах, түүнээс хэрхэн зааглаж ялгасан байхыг тодруулж мэдэх шаардлага үүснэ.

4) Хуулийн шууд зохицуулалт байхгүй буюу хийдэл гарсан. Хэрэглэх зохицуулалтыг олох эсхүл бий болгох.

Жишээ нь: Эдийн бус гэм хорыг арилгах /нас барсан хүний гэр бүл, ойр дотны хүмүүсийн сэтгэл санааны хохирол, амь нас алдсаны хохирол/ олон эргэлзээтэй, маргаантай асуудалд Иргэний хууль шууд ойлгомжтой хариуг өгөөгүй байдаг.

Дээрх дөрвөн тохиолдлын эхний хоёр нь хуулийн ухагдахуун, нэр томъёоны “цэвэр” явцуу хүрээний тайлбар шаардана. Харин гурав дахь тохиолдолд зөрчилдөөн шийдвэрлэх тусгай дүрэм баримтлах, алдааг засах системийн аргыг ашиглах, харин сүүлийн тохиолдолд хууль зүйн арга техникийг ашиглан хуулийг хэрэглэх, хэрэв ийм боломжгүй бол хуулийг өргөн хүрээнд тайлбарлах аргыг хэрэглэх боломжтой. Гэхдээ эдгээр тохиолдлыг шууд салгаж тусад нь шийдвэрлэхээс гадна хамтад нь шийдвэрлэх шаардлага ч цөөнгүй тохиолдоно. Энд дурдсан тохиолдол үүсэхгүй буюу хууль тухайн тохиолдолд хэрэглэгдэх нь маргаангүй, уг хуулийн агуулга илт ойлгомжтой байгаа бол хуулийг тайлбарлахгүйгээр шууд хэрэглэнэ. Харин ийм тохиолдол хувийн эрх зүйд түгээмэл биш юм.

Дүгнэхэд, иргэний эрх зүйн ихэнх маргааныг хууль тайлбарлахгүйгээр шууд хэрэглэж шийдвэрлэх боломжгүй. Маргааны хүрээ өргөн, олон талтай, хууль нарийн түвэгтэй, нүсэр бүтэц, тогтолцоо бүхий учраас хуульчийн хувьд ч тасралтгүй сургалт, практик судалгаагүйгээр асуудлын шийдлийг олоход бэршээлтэй.

VI. Иргэний хууль тогтоомжийг тайлбарлаж буй практик

Манай улсад албан ба албан бус тайлбар, норматив ба казуаль, шинжлэх ухааны үгчилсэн ба дэлгэрэнгүй тайлбарыг иргэний хууль тогтоомжийг зөв ойлгож хэрэглэх зорилгоор ашиглаж байна. Түүнчлэн хууль зүйн сургалт болон зөвлөгөө, өмгөөллийн практикт хуулийн тайлбарын олон төрөл чухал ач холбогдолтой.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлд “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” Улсын дээд шүүх (УДШ)-ийн бүрэн эрхийг тодорхойлсон байдаг. Энэхүү бүрэн эрхийн хүрээнд УДШ хууль тайлбарласан олон тооны тогтоол гаргаж ирсэн ба 2002 оны Иргэний хууль батлагдсанаас хойш 8 удаагийн тогтоолоор Иргэний хуулийн 2 бүлэг, 51 зүйлийг, 4 удаагийн тогтоолоор Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 бүлэг, 39 зүйлийг тус тус албан ёсоор тайлбарлажээ²⁷. Хувийн эрх зүйн бусад хуулийг тайлбарласан нийт 11 тогтоол гаргасан байна /Хавсралт хүснэгт үзэх/. Хууль тайлбарлахаас гадна УДШ-ийн танхим тус бүр хууль хэрэглэх, тэр дундаа хэрэг хянан шийдвэрлэх асуудлаар зөвлөмж гаргадаг практик өргөн дэлгэрсэн байна. Тухайлбал, УДШ-ийн Иргэний хэргийн танхим 2002-2012 онуудад иргэний хэрэг маргаан шийдвэрлэхэд анхаарах, хууль зөв хэрэглэх, нийтлэг жишиг тогтоох асуудлыг тусгасан судалгааны үр дүн, чиглэл, удирдамжийн шинжтэй нийт 30 зөвлөмж гаргажээ. Эдгээр зөвлөмж ихэнх тохиолдолд агуулга, хүчин чадлын хувьд хуулийн тайлбараас ялгагдахгүй болсныг ихээхэн шүүмжилдэг байлаа. Магадгүй энэ шүүмжийн улмаас зөвлөмж гаргах эрх зүйн зохицуулалт 2013 оноос хүчингүй болсон байна.

Өмнө дурдсан албан ёсны тайлбарыг хуулийн тодорхой зүйл, заалт, нэр томъёо бүрээр хийсэн байх ба ийнхүү тайлбар хийхдээ “...” гэдгийг ... гэж ойлгоно, “...” гэдэгт ... –г ойлгоно эсхүл хамааруулна гэсэн нийтлэг загварыг ашиглажээ. Системийн ба учир шалтгааны аргыг ихэвчлэн ашигласан нь иргэний эрх зүйн онцлогоос улбаатай. Агуулгын хувьд илүү дэлгэрүүлэн бусад зүйл заалттай холбож тайлбарласан, зарим тохиолдолд сурах бичиг, шинжлэх ухааны тайлбараас ялгагдахгүй байна. Гэхдээ энэ нь хууль тогтоогчийн хүсэл зориг төдийгүй эрх зүйн онолын тогтсон ойлголтыг хэт өргөжүүлэх эсхүл явцууруулах байдлаар хууль тогтоогчийн эрх мэдэлд халдах, буруу практикт хөтлөх эрсдэл дагуулна. Иймд УДШ иргэний хууль тогтоомжийг урьдчилан абстракт /хийсвэр/ байдлаар тайлбарлахаас аль болох татгалзаж, практикт маргаан дагуулсан хуулийн хэм хэмжээг нэг мөр ойлгож хэрэглэх үүднээс казуаль/жишгийн/ тайлбар

²⁷ Иргэний хэрэг: Эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. Эрхлэн эмхтгэсэн Жүгнээгийн Амарсанаа, Д.Баянбилэг, Улаанбаатар 2013, 422-424 дүгээр тал.

гаргах нь илүү зохистой.

2013 оны 4 дугаар сарын 15-ны өдрөөс мөрдөж эхэлсэн Шүүхийн тухай хуулийн²⁸ 17 дугаар зүйлийн 17.3.1-д “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргах бөгөөд тайлбарыг тогтмол нийтлэх” гэж заасны дагуу УДШ-ээс түүхэндээ анх удаа хяналтын шатны шүүх хуралдааны тогтоолуудыг эмхтгэн 201-2015 онд 6 дугаарыг хэвлэн нийтлүүлсэн байна. Анхны дугаарын өмнөх үгэндээ УДШ-ийн ерөнхий шүүгч Ц.Зориг “өмнө иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага хуулийг ойлгох, дагаж мөрдөх, хэрэгжүүлэх, хэрэглэх явцад гарсан эргэлзээтэй, салаа утгаар ойлгож болох заалтыг тайлбарлуулах тухай саналаар, тодруулбал, ихэвчлэн хуулийг хэрэглэхээс нь өмнө угтан тайлбарлаж, эрх зүйн харилцааг боловсронгуй болгох бус, харин хууль тогтоох эрх мэдлийн “дутууг дүүргэж, дундуурыг гүйцээдэг” минипарламентын чиг үүргийг хэрэгжүүлж байлаа ... Харин тодорхой хэрэг маргааныг хянан шийдвэрлэх замаар хуулийн албан ёсны тайлбар гаргах нь шүүх эрх зүйг бүтээж, шүүн таслах ажиллагаа дахь бас нэгэн шинэ хуудсыг эхлүүлсэн явдал” хэмээн бодит үнэнийг зөв дүгнэж хэлсэн байдаг²⁹. Түүнчлэн Шүүхийн ерөнхий зөвлөл 2014 онд гарсан шүүхийн шийдвэрүүдээс “үйл баримтыг эрх зүйн эх сурвалжтай бүрэн, зөв тулган шалгаж, эрх зүйн дүн шинжилгээ хийж, эрх зүйн хэм хэмжээг эрх зүйн онол, Үндсэн хуулийн болон эрх зүйн зарчимд тулгуурлан тайлбарлан хэрэглэж, шийдвэрийн үндэслэлийг дэлгэрэнгүй, тодорхой, ойлгомжтой, хууль зүйн техникийн шаардлагыг хангаж бичсэн байдал” зэрэг шалгуураар 77 шийдвэрийг сонгож олны хүртээл болгожээ³⁰.

Тодорхой хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ шүүхээс хууль тайлбарлан хэрэглэсэн үйл ажиллагаа, хуулийн тухайн зүйл заалтыг бодит тохиолдолд хэрхэн танин мэдэж ойлгосон тайлбарыг нийтийн хүртээл болгох арга замыг эрэлхийлж шүүхийн шийдвэрийн дээрх эмхтгэлийг гаргасан байна. Энэ бол зөв алхам бөгөөд цаашид тухайн хэрэг маргаан, түүнийг шийдсэн шүүгчийн шийдвэр, үндэслэл, хууль хэрэглээнд дүн шинжилгээ хийх ажлыг дэмжих, хэвшүүлэх шаардлагатай юм³¹.

²⁸ Энэ хууль 2021 онд шинэчлэгдсэн бөгөөд Улсын дээд шүүхийн энэ чиг үүргийг илүү дэлгэрэнгүй тодорхойлсон байна.

²⁹ *Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл*: Цуврал 1, (Улаанбаатар: 2015), 5 дахь тал.

³⁰ *Монгол Улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхтгэл*, I боть, (Улаанбаатар: 2015).

³¹ ШЕЗ-ийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн “Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачилсан зөвлөмж”-ийн төслийг 2015 оны 10 дугаар сард боловсруулан гаргаж, бусад байгууллага, хуульчдаас санал, дэмжлэг

Гэхдээ казуаль тайлбартай холбогдуулан Үндсэн хуулийн цэц (ҮХЦ)-ээс зарим иргэдийн мэдээллийн дагуу үндсэн хуулийн маргаан үүсгэж, 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 7 дугаар тогтоолоор Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргах...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4/ дэх заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах;”, Тавин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.” гэснийг тус тус зөрчсөн байх тул хүчингүй болгосугай гэж шийдвэрлэжээ³². УДШ-ийн бүх шүүгчдийн хуралдаанаас тайлбар гаргах ба УДШ-ийн аль нэг танхим нь УДШ-ийг төлөөлж тайлбар гаргах боломжгүй гэсэн утгаар ҮХЦ-ийн дээрх шийдвэр ойлгогдож байна. Уг шийдвэрээр норматив /заавал дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон/ эсхүл казуаль /жишиг тогтоосон/ тайлбар гаргах УДШ-ийн бүрэн эрхийн маргаантай асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй байна.

Манай улсад УДШ-ийн албан ёсны тайлбараас гадна 2002 оны Иргэний хуулийг тайлбарласан шинжлэх ухааны тайлбар нилээд гарчээ. Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг чухал үүрэг гүйцэтгэж, тайлбар гаргах ажлыг монголын төдийгүй германы хууль эрдэмтэд, шүүхийн шүүгч, багш нарт захиалан гүйцэтгүүлсэн байна. Үүний үр дүнд 2005 онд Иргэний хуулийн Ерөнхий ангийн тайлбар, 2008 онд Иргэний хуулийн тусгай анги /Гэрээний эрх зүй/-ийн тайлбарыг тус тус хэвлэн гаргасан ба 2010, 2015 онд энэ хоёр хэвлэлтийг нэгтгэн дахин хэвлүүлсэн байна³³. Энэхүү хэвлэлтээс үзэхэд Иргэний хуулийн гэрээний бус үүрэг, өвлөх, олон улсын иргэний эрх зүй гэсэн IY, Y, YI хэсэгт тайлбар хараахан хийгдээгүй аж.

Сүүлийн үед хувийн эрх зүйн салбарын судлаач, эрдэмтэн, мэргэшсэн хуульчдын тоо өсөж, иргэний болон бизнесийн эрх зүйн олон ном, сурах бичиг, нэг сэдэвт бүтээл, өгүүлэл, судалгааны тайлан, гарын авлага олон тоогоор хэвлэгдэн нийтийн хүртээл болж байна. Эдгээр бүтээл бүгд зохих хэмжээнд хуулийн үзэл баримтлал, онолын

авах ажлыг хийж байна. www.judcouncil.mn вэб хуудаснаас үзэх.

³² ҮХЦ-ийн 2015 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 3 дугаар дүгнэлтэд дурдагдсан шинжээч, доктор Н.Гантулга, доктор Д.Гангабаатар нарын гаргасан дүгнэлтийг үзэх.

³³ ХЗЯ. Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, *Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар* (Шинжлэх ухааны тайлбар), (Хоёр дахь удаагийн хэвлэлт), (Улаанбаатар: Мэргэн Их Монгол хэвлэлийн газар, 2015).

үндэс, үндсэн ухагдахуун, нэр томъёог танин мэдэх, тайлбарлан таниулах, практикт зөв хэрэглэх зорилгоор зохиогдсон ба сургалтад ашиглагдаж байна. Цаашид ийм албан бус тайлбар агуулсан сурах бичиг, хэрэг маргааны дүн шинжилгээ /case analyses/ хийсэн хууль зүйн бичлэг-өгүүлэл улам нэмэгдэх нь зүй ёсны үзэгдэл юм. Түүнчлэн УДШ-ийн албан ёсны абстракт/хийсвэр/ тайлбар багасч, ээдрээтэй хэрэг маргааныг шийдвэрлэх замаар хууль хэрэглээний жишиг тогтоосон шүүхийн түүхэн алдартай шийдвэрээр хууль зүйн шинжлэх ухаан хөгжих цаг үе ирнэ.

VII. Дүгнэлт

Хууль тайлбарлах нь хуулийг танин мэдэх арга, тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэх үндэслэл байхын зэрэгцээ хууль зүйн техникийн нэгэн чухал бүрдэл хэсэг болно. Хуулийн уг сурвалж, үзэл баримтлал, зорилго, чиг үүрэгт ач холбогдол өгөх үү, эсхүл хууль тогтоогчийн хүсэл зориг, эх бичвэрийн үг үсэг, шууд агуулгыг баримтлах уу, эсхүл цаг үеийн нөхцөл байдал, нийгмийн уур амьсгал, хүлээлтийг харгалзах уу, эсхүл уламжлал, ёс заншил, тогтвортой байдал, хатуу дэг журмыг чухалчлах уу гэдгээс тайлбар хийгч этгээдийн хандлага, тайлбарын үр дүн ихээхэн хамаарна. Хувийн эрх зүйд системийн болон учир шалтгааны аргыг ашиглан хууль тайлбарлах нь илүү зохимжтой бөгөөд түгээмэл юм.

Ихэнх улсын хувийн эрх зүйн хууль тогтоомж хоорондоо нийтлэг зүйл ихтэй бөгөөд урт хугацаанд шинжлэх ухааны түвшинд хөгжиж, амьдралын сорилт шаардлагыг даван гарч ирсэн ба өргөн агуулга, нарийн бүтэц тогтолцоотой, төрөлжиж эмхтгэгдсэн, тогтсон үзэл баримтлал, зарчим, нэр томъёо, ухагдахуунд үндэслэсэн байна. Энд хууль тогтоогчийн хүсэл зориг нэвтрэх зай завсар тун бага, мэргэшсэн хуульч, судлаач, эрдэмтдийн санал дүгнэлт давамгайлах хүчтэй. Ийм ч учраас тасралтгүй сургалт, онолын болон практик судалгаагүйгээр хувийн эрх зүйн салбарын хуулийг тайлбарлах, маргаантай асуудлын шийдлийг олоход бэршээлтэй.

Цаашид албан бус, шинжлэх ухааны тайлбар агуулсан сурах бичиг, хэрэг маргааны дүн шинжилгээ /case analyses/ хийсэн хууль зүйн бичлэг-өгүүлэл, ээдрээтэй хэрэг маргааныг шийдвэрлэж, хууль хэрэглээний жишиг тогтоосон шүүхийн шийдвэр нэмэгдэх хэрээр хууль зүйн шинжлэх ухаан хөгжинө.

[Ном зүй]

Бяраагийн Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: нийтлэг асуудал, Нэгдүгээр дэвтэр, Улаанбаатар, Улаанбаатар: Хууль зүйн үндэсний төв, 2004 он.

Даваасүрэнгийн Наранчимэг, Дунхүүгийн Аюуш, “Монгол Улсын иргэний хууль тогтоомж ба эрх зүйн шинэтгэл”, “Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил” бага хурлын илтгэлийн эмхтгэл, Улаанбаатар, 2004 он.

Должингийн Баярсайхан, Эрх зүйн онол, 3 дахь хэвлэл, Улаанбаатар: Эжитмо, 2010 он.

Жүгнээгийн Амарсанаа, “Монгол Улсын эрх зүйн тогтолцоо ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил” “Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил” бага хурлын илтгэлийн эмхтгэл, Улаанбаатар, 2004 он.

Иргэний хэрэг: Эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. Эрхлэн эмхтгэсэн Жүгнээгийн Амарсанаа, Д.Баянбилэг, Улаанбаатар 2013 он.

Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмхтгэл: Цуврал 1, Улаанбаатар: 2015 он.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 03 сарын 11-ний өдрийн 03 дугаар дүгнэлт, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=10967>.

Монгол Улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхтгэл, I боть, Улаанбаатар: 2015 он.

Монсудар хэвлэлийн газар, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, Монгол хэлний хураангуй тайлбар толь бичиг Анхны хэвлэл, Улаанбаатар: Монсудар, 2009 он.

Моригива Яасутомо, “Хуулийг тайлбарлан хэрэглэх ажиллагаанд тогтвортой байдал ба шударга ёс зэрэгцэн орших нь”, Шүүх эрх мэдэл сэтгүүл, (3), 2015 он.

Нанзаддоржийн Лүндэндорж, “Хууль тайлбарлан хэрэглэх онол, арга зүй” Шүүх эрх мэдэл, (1), 2015 он.

Роналд Дворкин, Хуулийн эзэнт гүрэн (Орч. Я.Очирсүх), ХЗҮХ-ийн хэвлэх үйлдвэр, 2015 он.

Содовсүрэнгийн Нарангэрэл, Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо, Улаанбаатар: Адмон, 2001 он.

Түмэнжаргалын Мэндсайхан, Монгол Улсын Иргэний хуулийг ХБНГУ-ын Иргэний төрөлжсөн хуультай харьцуулан судлах нь, Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил” бага хурлын илтгэлийн эмхтгэл, Улаанбаатар, 2004 он.

Фрэнсис Фукуяама, Улс төрийн тогтолцооны сурвалж, (Орч. Э.Ариунсанаа), II боть.

Ханс Кельзен, Хэм хэмжээний тухай ерөнхий онол, (Орч. М.Хатанбаатар), Мэргэн Их Монгол, 2013 он.

- Хутыз М.Х. Римское частное право: Курс лекций. – М.: Былина, 1994.
- Чойжилын Нямсүрэн, Эрх зүй, төрийн ерөнхий онолын зарим асуудал, (Улаанбаатар: 1995 он.
- ШЕЗ-ийн дэргэдэх Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачилсан зөвлөмж, www.judcouncil.mn, 2015 он.
- Black's Law Dictionary, 7th ed., 1999.
- Cicero: de Legibus III.
- Friedrich A. Hayek, Law, Legislation and Liberty, University of Chicago press, 1976.
- Kent Greenawalt, Legal Interpretation: Perspectives from other Disciplines and Private Texts, Oxford University Press, 2010.
- Reinhold Zippelius, Juristische Methodenlehre, 10., neu bearb. Aufl., München, Deutschland, 2006.
- Savigny, System des heutegen Roemischen Rechts I, 1840.

[Abstract]

Features of Legal Interpretation in Private Law

Mendsaikhan Tumenjargal

Doctor of Laws (Ph.D.).

Associate Professor at the Private Law Department

School of Law, National University of Mongolia

Ulaanbaatar, Mongolia

Legal interpretation is a method for understanding the law and serves as a foundation for resolving specific disputes, and it is also a crucial aspect of legal technique. Although laws and legal documents have unique characteristics, it is appropriate to apply common methods of “interpretation” and general theories from other fields to the legal field. The approach of the interpreter and the results of interpretation mainly depend on whether to focus on the source, concept, purpose, and function of the law or to follow the legislator’s intent, the literal meaning, and the direct content of the original text, or to consider current circumstances, social climate, new demands and expectations, or to emphasize tradition, customs, stability, and strict order. There are subjective and objective approaches to interpreting law. The approaches and methods of interpretation in public and private law are quite different. In private law, it is more common to interpret law using systematic and causal methods, and to prefer objective approaches. Mongolia continues to face challenges in developing methods for applying and interpreting the law, reducing the arbitrary power of law enforcement officers and judges to appropriate levels, and establishing a unified legal practice. This article explores the concepts, methods, and approaches to interpreting legal norms for resolving specific disputes, as well as the nuances of legal interpretation in private law and current practices in our country.

[Keywords]

Civil Code of Mongolia, Application of law, Interpretation of law, Formal interpretation of law, Legal technique, Subjective approach, Objective approach, Linguistic method, Historical method, Systemic method, Causal method, Competing norms, Divergent meaning, Legal ambiguity.